



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2024 оны 12 сарын 13 өдөр

Дугаар А/511

Улаанбаатар хот

Томуу, томуу төст өвчний (дагшуур)  
уламжлалт анагаах ухааны оношилгоо,  
эмчилгээний заавар

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг  
Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалт, 36 дугаар зүйлийн  
36.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Томуу томуу төст өвчний (дагшуур) уламжлалт анагаах ухааны оношилгоо, эмчилгээний заавар”-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү зааврыг мөрдөж ажиллахыг өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.
3. Зааврыг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, хүний нөөцийг чадавхжуулах, эмч, эмнэлгийн мэргэжилтэнд шаардлагатай сургалтыг зохион байгуулж ажиллахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв (Б.Нарантуяа), Эрүүл мэндийн яамны дэргэдэх Уламжлалт анагаах ухаан судлалын мэргэжлийн салбар зөвлөл (Д.Цэнд-Аюуш)-д тус тус даалгасугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн бодлогын газрын дарга (Р.Гантуяа)-д үүрэг болгосугай.

САЙД



Т.МӨНХСАЙХАН

141242346

Эрүүл мэндийн сайдын  
2024 оны 16 дугаар сарын 13-ны өдрийн  
А/..... дугаар тушаалын хавсралт  
511

## ТОМУУ, ТОМУУ ТӨСТ ӨВЧНИЙ (ДАГШУУР) УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫ ОНОШИЛГОО ЭМЧИЛГЭЭНИЙ ЗААВАР

### А. ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

#### А.1 Онош:

Увдисын үндсийн 27 дугаар бүлэг, халуун өвчнийг анагаах үесийн Дагшуур (томуу) хижиг өвчин.

**А.2 Оношийн код:** ЭМС-ын 2022 оны 1 дүгээр сарын 28-ы өдрийн А/55 тоот тушаал ТМГ10.5 Дагшуур (томуу) хижиг

#### А.3 Хэрэглэгчид:

- Уламжлалт анагаахын их эмч
- Уламжлалт анагаах ухааны хүүхдийн эмч
- Уламжлалт анагаах ухааны дотрын эмч
- Уламжлалт анагаах ухааны заслын эмч
- Уламжлалт анагаах ухааны мэдрэлийн эмч
- Монгол анагаах ухаан судлалын эмч
- Уламжлалт анагаах ухааны эмэгтэйчүүдийн эмч
- Монгол эм судлал
- Резидент эмч

#### А.4 Зорилго:

Томуу, томуу төст өвчнийг (дагшуур хижиг) уламжлалт анагаах ухаанаар оношлох, эмчлэх эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтнийг мэргэжил, арга зүйгээр хангах.

#### Зорилт:

1. Томуу, томуу төст (дагшуур хижиг) өвчнийг оношлох, эмчилгээний арга зарчмыг боловсруулах
2. Эмчилгээний дөрвөн ерөндөг (арга) болох идээ ундаа, явдал мөр, эм, заслаар эмчлэх эмчилгээний алгоритмыг боловсруулах
3. Томуу, томуу төст (дагшуур хижиг) өвчнөөс уламжлалт анагаах ухааны аргуудаар урьдчилан сэргийлэх

#### А.5 Зааварт ашигласан нэр томъёо, тодорхойлолт, эх сурвалж:

А.5.1 Дагшуур хижиг\* (томуу) нь нянгийн халдварт өвчин бөгөөд агаар болон идээ ундны бохирдол, тоос тоосонцор, агаарын чийгшил багатай орчин, утаа хэншүү, хурц үнэртэй зүйл нь өвчнийг сэдэрээх нөхцөл болдог ч гол нь халдвар авсан хүнээр дамжин агаар дуслаар буюу хамрын нүхээр дамжин дотогшилж өвчин болон хувирдаг. Жилийн



аль ч улиралд тусдаг ч голлон хавар, өвлийн улиралд уур амьсгалын өөрчлөлтөөс болж өвчлөл үүсэх нь их байдаг.

А.5.2 Уламжлалт анагаах ухааны эмчилгээний дөрвөн ерөндөг буюу идээ унд, явдал мөр, эм, заслаар анагаана.

А.5.3 Уул талын завсар нь халуун хүйтний хувиар зааг буюу халуун барагдсаны дараа хүйтэн хий үүсэхийн завсар болно.

А.5.4. Хижиг\* - амьсгал, шүлс, хөлс зэргээр хүний биед нэвтэрч орох гэсэн нь нян, вирусийн халдвар ам хамар, бохир гараар дамжихыг өгүүлсэн.

А.5.5. Идээ ундааг тэнцүүлээгүй\* - өлсөж ядрах, гэнэт их идэх зэргээр биеийг хямраах.

А.5.6. Биедээ зохихгүй зүйл эдэлсэн\* - нь нойр хоол дутуу явж ядарч зүдрэх, амралтгүй ажиллах, даарч хөрөх зэрэг нөхцөлүүд

А.5.4 Эмийн үйлдлийн төрлүүд:

- Боловсруулах – Өвчний эхний үед боловсроогүйг боловсруулах
- Ялгах – Хавсарсан өвчнүүдийг ялгах
- Хураах – Хийгээр сарнисныг хураах
- Нядлах – Өвчнийг дарах, арилгах
- Тэнсэх – Уул талын завсрыг магад таниулах, шинжлэн судалж хэмжээг мэдэх, байдлыг тандах, ерөндөг тохирох эсэхийг сорьж мэдэх зэрэг
- Ирүүлэх /татах/ – Хийг дарж, эмчлэхэд хялбар болгох
- Хатаах – Шар усыг хатаах /булингартсан халуунд/
- Тэтгэх – Биеийн тамир, галын илчийг сайжруулах
- Хөөх – Халууныг биеэс гадагшлуулах

## А.6 Тархвар зүй

Монгол орны цаг уурын онцлогтой холбоотойгоор өвөл, хаврын улиралд болон улирал солигдох үед томуу, томуу төст өвчний өвчлөл нэмэгддэг. Тус өвчний халдварлах зам нь хүний хамрын нүх, шар үсний сүвээр өвчин үүсгэгч нян /вирус/ хүний биед орж цусны хорхойтой нийлэлдэн судсаар дамжиж долоон тамирыг хямралдуулах бөгөөд хувь хүний нас, төрөлх өвөрмөц чанартай холбоотойгоор илрэх шинж тэмдэг харилцан адилгүй байна.

## А.7 Үндсэн ойлголт

Уламжлалт анагаах ухааны өвчний ангиллаас Халуун өвчнийг анагаах үесийн Дагшуур (томуу) хижиг өвчин /ТМГ10.5/ нь дотроо хамрын дагшуур томуу, хоолойн дагшуур томуу, уушгины дагшуур томуу, халдварт дагшуур томуу гэж ерөнхий 4 ангилагдана. Үе шатаар нь эс боловсорсон халуун, дэлгэрсэн халуун, хоосорсон халуун, эдгэрлийн үе гэж ангилна.

Түүнчлэн дагшуур ханиад ТМК01.1, уушгины халуун ТМК01.2.1, огшрон ханиах ТМК01.3.2, уушгины архаг ТМК01.04.1, уушги дэлгэрэх ТМК01.04.2 зэрэг өвчний шалтгаан, нөхцөл, өвчин болох ёс, илрэх шинж тэмдгүүд нь дагшуур (томуу) хижиг өвчний эмнэл зүйгээр ялган оношлох шаардлагатай.

Дагшуур (томуу) хижиг өвчнийг зөв оношилж, үе шатыг зөв тогтоох нь уламжлалт анагаах ухааны эмчилгээний дөрвөн ерөндгөөр өвчнийг богино болон урт хугацаанд анагаах, хүндрэлээс сэргийлэх, эдгэрэлтийг түргэсгэх, эмчилгээний үр дүнг нэмэгдүүлэх, дархлааг тэнцвэржүүлэх, эмийн зохистой хэрэглээг бий болгох ач холбогдолтой юм.

## **А.8 Өвчний тавилан:**

Өвчний эхэн үе шатанд идээ ундаа, явдал мөр, эм, засал эмчилгээг тохируулан хийснээр эс боловсорсон халуун цагтаа боловсорч эдгэрэлт түргэн явагдана. Эмчилгээ хожимдох, буруудах, илүүдэх, эртдэх, хожимдох болон тухайн хүний өвөрмөц чанараас шалтгаалан халдварт нян цусанд гүйж судсаар дамжин, биеийн бүх хэсгээр тархаж долоон тамирыг хямраах, өвчний үе шат боловсорч чадахгүйгээс дараах өвчнүүдэд хүндэрч болно. /ТМК01.1-ТМК01.04, ТМГ02.1-ТМГ02.3, ТМГ07.8, ТМГ04.9, ТМГ10.1/

- Уушгины халуун
- Огшрон ханиах
- Уушгины архаг
- Уушги дэлгэрэх
- Булингартсан халуун уушгинд буусан
- Уушгины хоосорсон халуун
- Халдварт хижиг

## **Б. ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭНИЙ ДЭС ДАРААЛАЛ /АЛГОРИТМ/**

### **Б.1 УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ЭРТ ИЛРҮҮЛЭХ**

#### **Б.1.1 Анхдагч урьдчилан сэргийлэлт.**

- Идээ ундаа - Хоол цайг халуун, бүлээнээр хэрэглэж хэвших, өөрийн аяга, халбагыг угааж хэрэглэх, цэвэр орчинд гүйцэд болгосон хоол ундыг идэх, идээг тэнцүүлэх;
- Явдал мөр- Сайн амарч унтах, ажил амралтыг зохицуулж ядрахгүй байх, сэтгэл санаагаа тайван байлгах улирлын цаг агаарт тохируулан дулаан хувцаслах, дулаан байр сууцанд амьдрах, ажиллах, агаарын солилцоог тогтмол хийх;
- Мана-4 танг хүүхэд хөгшид, Норов-7 танг идэр залуу насныхан оройд 1 удаа 1 граммыг 200 мл ус болон шөлөнд 3-5 минут зөөлөн гал дээр буцалгаж, гэр бүлээрээ ууж, дархлаагаа дэмжих (Жич: Мана-4 болон Норов-7 тангийн найрлагад орсон эмийн түүхий эдүүдэд харшлын өгүүлэмжгүй байх)
- Хоолойг жамц давсны уусмалаар өдөрт 1 удаа зайлуулах.


#### **Б.1.2 Хоёрдогч урьдчилан сэргийлэлт.**

- Хувь хүний өвөрмөц чанартай уялдуулан хоёрдогч урьдчилан сэргийлэлтийг идээ ундаа, эм, заслаар хийх бөгөөд тамир дорой, цус багадалттай, архаг суурь өвчтэй хүүхэд болон насанд хүрэгчдэд махбодыг тэгшитгэх, шимжүүлэх эм тан, заслын эмчилгээг хийх;
- Өвчинд өртөмтгий, суурь өвчтэй болон хүүхэд, хөгшдийг хавар, намрын сүүл сар, өвлийн эхэн сар сэрүүний улиралд дархлаа тэнцвэржүүлэх Мана-4 эсвэл Норов-7 тан эмийг орой бүр 1 граммыг 200 мл ус болон шөлөнд 3-5 минут зөөлөн гал дээр буцалгаж, 3-5 хоног уулгана.
- Мөн ханиад амархан хүрдэг хүүхдэд Сороол-4 танг орой бүр 1 граммыг 200 мл сүү, эсвэл усанд 3-5 минут зөөлөн гал дээр буцалгаж, 3-7 хоног бүлээнээр нь оройд уулгах, жамц давсны уусмалаар эсвэл эмчийн зөвлөсөн эм тангаар зааврын дагуу хоолойг зайлна. (Сороол-4 тан бадган салс арвидсан цэр ихтэй үед усанд буцалгаж уух)
- Өглөө, оройд толгойн орой, гарын алгыг шар тос, сүүлэн тосоор илж хийг дарж бие махбодыг чийрэгжүүлэх.



## В.1 ЗОВУУРЬ, ЭМНЭЛЗҮЙН ШИНЖ

Алгоритм 1. Оношилгоо, эмчилгээний алгоритм



Хүснэгт 1. Өвчний үе шатанд гарах эмнэл зүйн шинж тэмдэг

Үе шат Ангилал	Өвчний эхэн үе /Эс боловсорсон/	Өвчний дунд үе /Дэлгэрсэн халуун/	Өвчний сүүл үе /Удаж хуучирснаар хүйтний шинж давамгай байна/
<b>Хамрын дагшуур томууны үед</b>	Шингэн ус гоожих, хамар битүүрэх олон дахин найтаах, чихээр үе үе хатгах, толгой өвдөх шинж гарна.	Хамар битүүрч ногоон нус гарах олон дахин найтаах, толгой өвдөлт илүү хүчтэй болно.	Хамар хуурайшна, чих шуугих, нүдний ухархайгаар хатгах, толгой хүндэрч өвдөх шинж гарна.
<b>Хоолойн дагшуур томууны үед</b>	Хоолой, тагнай, багалзуур халуун оргих, шингэн ус гоожих, хоолой сөөх, хоолонд дургүй болж жихүүдэс хүрнэ.	Хоолой, тагнай, багалзуур халуун оргих, хоолой торж өвдөх шүлс залгих, юм идэж уухад өвдөлт нэмэгдэнэ, хоолой сөөх, хоолонд дургүй болох, халуурах шинж гарна.	Хоолой сөөх, хоолойн өвдөлт ойр ойрхон сэдэрч өвдөх, зүрх үе мөчөөр хэсэж хатгуулах шинж гарна.
<b>Уушгины дагшуур томууны үед</b>	Хоолой, тагнай, багалзуур халуун оргих, ханиалгана, цээж хөндүүрлэх, хоолонд дургүй болно, жихүүдэс хүрэх бие сулрах, нойр муу болох шинж гарна.	Цэрний өнгө хувирна, бие сулрах, халуурах шинж гарна.	Цэр өтгөрөх, турах, олон дахин ханиалгах, бөөлжих, хоолны дуршилгүй болох, галын илч буурсан шинж гарна.
<b>Халдварт дагшуур томууны үед</b>	Оршсон орноос хамаараад дээрх шинжүүд илрэх бөгөөд илүүтэй эс боловсорсон халууны шинж буюу халуурах, жихүүдэс хүрэх шинж гарна.	Оршсон орноос хамаараад дээрх шинжүүд илрэх бөгөөд илүүтэй дэлгэрсэн халууны шинж буюу халуурах шинж гарна.	Оршсон орноос хамаараад дээрх шинжүүд илрэх бөгөөд хуучирсан, нуугдсан, хоосорсон шинжүүд илүүтэй гарна.

## В.2 УАУ-Ы ОНОШИЛГОО: ҮЗЭХ, ХҮРЭЛЦЭХ, АСУУХ ШИНЖИЛГЭЭ

### В.2.1 Асуух шинжилгээ:

Халдвар авсан эхний өдрөөс 7 хоног хүртэлх хугацаанд халдвар тараах боломжтой тул өвчтэй хүнтэй ойр байсан эсэхийг асууна.

Мөн уламжлалт анагаах ухааны онцлог асуумжийг асууна. Үүнд: Цаг агаар, уур амьсгалын гэнэтийн өөрчлөлт, салхинд цохиулах, даарч жиндэх, халууцсаны дараа хүйтэн юм уух, утаа тоос, элдэв хурц үнэрээр бохирдсон орчинд удаан ажилласан зэрэг.

### В.2.2 Үзэх шинжилгээ:

*Хүснэгт 2. Үзэх шинжилгээгээр гарах эмнэл зүйн өөрчлөлтүүд*

Үзэж шинжлэх	Өвчний эхэн үе (эс боловсорсон)	Өвчний дунд үе (дэлгэрсэн)	Өвчний сүүл үе
Хэл	Хуурай, нимгэн өнгөртэй, уг хэсгээрээ хийн гүвдрүүтэй	Хуурай, шар өнгөтэй, зузаан өнгөртэй	Өнгөргүй, чийглэг нойтон
Хамар, уруул	Хатна, шингэн нус гоожно, хамар битүүрнэ.	Шар өтгөн нус гарна, уруул хатаж омголтоно.	Цайвар өтгөн нус гарна. Уруул хатна.
Гүйлсэн булчирхай	Улаан ягаан өнгөтэй.	Гүйлсэн булчирхай 2 талдаа гадаргуу улайсан, өнгөртэй.	Улаан ягаан өнгөтэй .
Цэр	Цэргүй	Шар заримдаа ногоон туяатай цэр гарна.	Цайвар зууралдсан цэр гарна.
Шээс	Цайвар шар өнгөтэй	Улаан, улбар шар, муухай үнэртэй, уур их, зузаан язмагтай байна.	Улаан шар, өтгөн, булингартай.
Чихний судас /0-3 насны хүүхэд/	Уушгины судас тодорно, 2 чихний дээд судас тодорно.	Өнгө нь улайна, салбарлаж тодорно.	Удаж хуучирвал хөхөрнө, элэгний судас хөхөрч тодорно.

**Нэмэлтээр заавал хийх үзлэг, шинжилгээ:**

**Хамрын дагшуур томууны үед:** Чих хамар хоолойн ерөнхий үзлэг хийх

**Хоолойн дагшуур томууны үед:** Хоолой тагнай, гүйлсэн булчирхайн үзлэг хийх

**Уушгины дагшуур томууны үед:** Цээж чагнах, шаардлагатай бол рентген зураг

**Халдварт дагшуур томууны үед:** Амин үзүүлэлт үзэх



### В.2.3 Хүрэлцэх шинжилгээ:

Хүснэгт 3. Хүрэлцэх шинжилгээгээр гарах эмнэл зүйн өөрчлөлтүүд

Хүрэлцэх шинжилгээ	Өвчний эхэн үе (эс боловсорсон, хоосорсон, булингартсан)	Өвчний дунд үе (дэлгэрсэн, булингартсан, хоосорсон)	Өвчний сүүл үе (хуучирсан, нуугдсан, хоосорсон, булингартсан)
Судас Улирал, өвөрчлөл, нас, буусан орны хамаарлыг тооцох.	Нарийн, түргэн, хоосон, хөлбөрөнгүй лугшилтын аль нь ч илэрч болно.	Эрчимтэй, дэлгэрэнгүй чанга, овойж хуйларч, хатуу, түргэн лугшилтуудын аль нь ч илэрч болно.	Живэнги, доороо эрчимтэй, хөлбөрөнгүй, дорой лугшилтуудын аль нь ч илэрч болно.
Бэлчир /Чагнах, тогших, хүрэлцэх/	Чагнахад цулцангийн амьсгал ширүүссэн, амьсгалын тоо олшрох.  Хүрэлцэхэд арьс, 4 толио хүйтэн.	Чагнахад эмгэг шуугиан сонсогдоно. Тогшиход цээжний хоёр талд адил бус, Нурууны (Th 3/4, 4/5) 4,5-р эх, хөвгүүн бэлчир орон эмзэглэлтэй байж болно.	Чагнахад амьсгалд оролцохгүй байгаа хэсэг тодорхойлогдоно. Тогшиход дүлий чимээ илрэх. Сээрний нугалмууд, өвчүү хавирганы нум дагаж эмзэглэлтэй.
Галын илч	Тэнцвэргүй	Бадрах	Буурах

### В.2.4 Лабораторийн шинжилгээ:

Өвчний эхэн үед хурдавчилсан оношлуур эсвэл полимеразийн гинжин урвал (ПГУ)-ын шинжилгээг хийж вирусийн үүсгэгчийг тодруулж болно. Мөн эмнэлзүйн илрэл, үзэх, хүрэлцэх, асуух аргаар оношлон эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байгаа үйлчлүүлэгчийн цусны дэлгэрэнгүй шинжилгээ, биохимийн шинжилгээ, CRP бусад шаардлагатай үзүүлэлтүүдээр хянаж сайжрал илрээгүй байвал дараагийн шатлалын эрүүл мэндийн байгууллагад шилжүүлнэ.

### В.2.5 Багажийн шинжилгээ

Эхэн, дунд, сүүл үеийн шинж тэмдэг илрэх багасахгүй, халуурах, цэр гарах, ханиалгах нь их бол цээжний рентгенээр хянахад сайжралгүй бол дараагийн шатлалын эрүүл мэндийн байгууллагад шилжүүлнэ.

### В.2.6 Ялган оношилгоо

Дагшуур өвчнийг 4 ангилна. Энэ ангиллаар хүндрэлийг тооцох боломжтой.

- Хамрын дагшуур
- Хоолойн дагшуур
- Уушгины дагшуур
- Хижиг дагшуур



Хүснэгт 4. Ялган оношилгоонд гарах эмнэл зүйн өөрчлөлтүүд

Ялган оношилгоо	Хамрын дагшуур томуу	Хоолойн дагшуур томуу	Уушгины дагшуур томуу	Халдварт дагшуур томуу
Ижил төстэй шинж тэмдэг	Хамар халуун оргино.	Тагнай, самалдаг халуу оргино.	Хоолой халуун оргино.	Бүрий цагаар бүх бие халуу оргино.
	Хамраан ус их цувирна.	Хамраас цус цувирна.	-	-
	-	-	Толгой, өвчүү, ар далаар өвдөнө.	Толгой, том үе, булчин өвдөнө.
Өвөрмөц шинж тэмдэг	Хамар загатнана.	Самалдаг хавагнах, Олон угсруулан найтаана.	Хоолой сөөнө, олон ханиалгаж, өгөртэй цэр гарч, уушгины архаг болно.	Ам гашуу оргиж, дуршил амаргүй, жихүүцэж, бүх биеэр хөндүүрлэж өвчин орно.

**В.3 ЭМЧИЛГЭЭ: ИДЭЭ УНДАА, ЯВДАЛ МӨР, ЭМ БОЛОН ЗАСАЛ 4 ЕРӨНДГИЙГ ХЭРЭГЛЭНЭ.**

**В.3.1 Идээ, ундаа:**

Шингэц сайтай, хонь, үхрийн махтай халуун шөлтэй хоол, сонгино саримс, буцалгасан халуун бүлээн ус, зөгийн балтай ус, хийцтэй цай, сүүтэй цай, аарц, айраг, үзэм, чацарганын халуун бүлээн шүүс зэрэг илчлэг, шимтэй хоол унд хэрэглэж биеийн хүч тамирыг тэтгэнэ. Хоолны хэмжээг ихдүүлэх, эхнийх нь шингээгүй байхад дахин идэх, оройн хоолыг хэт оройтуулж хэрэглэхгүй, хүйтэн ус, ундаа уухаас татгалзах хэрэгтэй.

Хүснэгт 5. Идээ ундыг өвчний үе шаттай уялдуулах

Үе шат	Өвчний эхэн үе	Өвчний дунд үе	Өвчний сүүл үе
Идээ, ундаа	Сэрүүн бүлээн тэгш, хөнгөн чадалтай шингэхэд хялбар идээ ундааг өгнө.	Өвчний хүчтэй уялдуулсан идээ ундааг өгнө.	Биеийн тамир, галын илчийг тэтгэнэ.

**В.3.2 Явдал, мөр:**

Хүйтний улиралд дулаан хувцас өмсөх, даарахгүй байх, ядрахгүй байх, хурц үнэр, хэншүү утаа, тоосноос хамгаалах, сэтгэл санааг тайван байлгах, тамхи татахыг хориглох, агааржилт сайтай дулаан чийглэг байр орчинд байлгах, эмийн жорын дагуу найруулсан үнэрийн чадалтай эм болон эмт бодис зүүх.

### В.3.3 Эмийн эмчилгээ:

Алгоритм 2. Эмийн эмчилгээний зарчим




Хүснэгт 6. Эмийн эмчилгээг өвчний үе шаттай уялдуулах

Үе шат	Өвчний эхэн үе	Өвчний дунд үе	Өвчний сүүл үе
<b>Эмийн эмчилгээ</b>	Тэнсэх, боловсруулах, хураах зорилгоор эмийн уураар утах, бүлээтгэж хоолой зайлах, ойр ойрхон уулгана	Нядлах, татах, хураах, ялгах зорилгоор эмийг ойр ойрхон, хавчуулан, ээлжилж уулгана.	Тэнсэх, тэтгэх, татах, хөөх зорилгоор эмийг хөлөглөж уулгана.
Уламжлалт эмийн тунг тохируулах арга <ul style="list-style-type: none"> <li>• Хөхүүл үед эхэд уулгана.</li> <li>• Бор хоолонд орсон үед хүүхэд, эх хоёуланд уулгана.</li> <li>• Насанд хүрсэн хүнд 1-2 гр-аар уулгана.</li> <li>• 1-5 насны хүүхдэд насанд хүрэгчдэд хэрэглэх хэмжээний дөрөвний нэг хувийг өгнө.</li> <li>• 6-15 настай хүүхдэд насанд хүрэгчдэд хэрэглэх хэмжээний хоёрны нэг хувийг өгнө.</li> </ul>			

**Үндсэн эм:** Норов-7, Мана-4, Лидэр-7 тан, Ванжин-15, Лишь-6, Чун-5, Сороол-4, 7, 11; Дарву-5, Лоцадгүнсэл, Жуган-5, 9, 25; Банздоо-12, Зову-8, Үзэм-7, 11, Монфлю зэрэг эмүүдээс сонгож зааврын дагуу хэрэглэнэ .



### Алгоритм 3. Эмийн эмчилгээний алгоритм



**Хавсран уух эм:** Илэрч буй шинж тэмдэг, өвчний хувиралтай уялдуулан эмийн эмчилгээг сонгоно

**Ханиалга намдаах:** Сороол-4,7, Дарву-5, Жуган-5, 9,25, Үзэм-7 зэрэг эмүүдийг зааврын дагуу өдөрт 1-2 удаа өвчний үе шаттай уялдуулан ууна.

**Халуун бууруулах, өвдөлт намдаах:** Чун-5\*, Лидэр-7, Мана-4, Норов-7, Зову-8\*,25\* эмүүдийг зааврын дагуу өдөрт 1-2 удаа ууна. Хоолойн өвдөлтийг намдаахад Ванжин-25, Лишь-6 зэрэг эмүүдийг 1-2 граммаар буцалсан усанд бүрж, хоолойг зайлах маягаар тогтоож өдөрт 6 цагийн зайтай хоолойн өвдөлт намдтал хэрэглэнэ.

**Цэрний өнгө, хэмжээ өөрчлөгдөх үед:** Сороол-4,7, Лоцадгүнсэл 4, Жамц-4 эмүүдийг зааврын дагуу өдөрт 1-2 удаа ууна. (\*- хавсарсан хурсан болон тунгалаг, цөв эс шингэсэн харшлын суурьтай бол талхдаж нунтагласан эмүүдийг анхааралтай хэрэглэх)

### В.3.4 Засал эмчилгээ:

Хүснэгт 7. Өвчний үе шат, засал эмчилгээ

Үе шат	Өвчний эхэн үе	Өвчний дунд үе	Өвчний сүүл үе
<b>Арилгах эмчилгээ</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Хамрын эм</li> <li>• Жамзи</li> <li>• Нируха</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Туулга</li> <li>• Бөөлжүүлэг</li> <li>• Хамрын эм</li> <li>• Нируха</li> <li>• Зөгийн балтай татлага</li> <li>• Судсан туулга</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Бөөлжүүлэг</li> <li>• Хамрын эм</li> <li>• Жамзи</li> <li>• Зөгийн балтай татлага</li> <li>• Судсан туулга</li> </ul>
<b>Заслын эмчилгээ</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Төөнүүр</li> <li>• Зэтрээс цус гаргах</li> <li>• Дэвтээлэг</li> <li>• Жин</li> <li>• Түрхлэг</li> <li>• Бариа засал /дөрвөн толио/</li> <li>• Зүү эмчилгээ</li> <li>• Соруул</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Төөнүүр</li> <li>• Хануур</li> <li>• Шивүүр</li> <li>• Хатгуур</li> <li>• Дэвтээлэг</li> <li>• Жин</li> <li>• Түрхлэг</li> <li>• Бариа засал</li> <li>• Зүү эмчилгээ</li> <li>• Соруул</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Төөнүүр</li> <li>• Хануур</li> <li>• Шивүүр</li> <li>• Хатгуур</li> <li>• Дэвтээлэг</li> <li>• Жин</li> <li>• Түрхлэг</li> <li>• Бариа засал</li> <li>• Зүү эмчилгээ</li> <li>• Соруул</li> </ul>

Тайлбар: Үйлчлүүлэгчийн нас, хүйс, өвөрчлөл, цаг, улирал, онцлогтой нь уялдуулан арилгах эмчилгээ, заслын эмчилгээг хийнэ.



## В.4 ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ДАРААГИЙН ШАТЛАЛД ИЛГЭЭХ ЗАРЧИМ, ШАЛГУУР

Дараах тохиолдолд аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг болон төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгт илгээнэ. Үүнд:

1. Уушгины хатгалгаа оношлогдсон тохиолдолд давтан үзлэгээр эмнэлзүйн шинж тэмдгүүд сайжраагүй эсвэл биеийн байдал дордсон;
2. Хүндэвтэр ба хүндрэлтэй хатгалгаа;
3. Тавилан таагүй шинжүүдээс аль нэг нь илэрсэн;
4. Өвчний идэвхжил дунд болон өндөр байх;
5. Эмийн эмчилгээний гаж нөлөө илэрсэн;
6. Бусад эрхтэн тогтолцооны талаас хүндрэл;

Шаардлагатай тохиолдолд бусад мэргэжлийн эмч нартай хамтран ажиллана.

*Хүснэгт 8. Эрүүл мэндийн байгууллагын тусламж үйлчилгээ үзүүлэх заавар*

Эрүүл мэндийн байгууллага	Эмчилгээний төрөл				Өвчний үе шат		
	Урьдчилан сэргийлэх	Эмийн эмчилгээ	Арилгах эмчилгээ	Заслын эмчилгээ	Өвчний эхэн үе	Өвчний дунд үе	Өвчний сүүл үе
Анхан шатны эрүүл мэндийн байгууллага, оргүй клиник	+	+	+/-	+/-	+	+/-	+/-
Лавлагаа шатлал	+	+	+	+	+	+	+

## Г. ЭРҮҮЛ МЭНДИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ

1. Үйлчлүүлэгчид уламжлалт анагаах ухааны эмчилгээний онцлогийг таниулах мэдлэгтэй болгох;
2. Эмчилгээ хийх үед анхаарах зүйлс, гам дэглэмийг тайлбарлах;
3. Өвчнөөс урьдчилан сэргийлэлтийн талаар мэдээлэл, зөвлөгөө өгөх;
4. Гэр бүл, хамт олноороо дасгал хөдөлгөөн тогтмол хийх;
5. Хувийн ариун цэврийг сайтар сахих;
6. Орон байрандаа агааржуулалтыг тогтмол хийж хэвших.